*Төсөл*

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

200 оны сарын өдөр Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

## Нийтлэг үндэслэл

**дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**дугаар зүйл. Төсвийн тухай хууль тогтоомж**

1.2. Төсвийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлж гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

1.3. Энэ хууль нь төсвийн байгууллага, албан тушаалтан Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна.

1.4. Энэ хуулийн хөтөлбөрийн төлөвлөлт, үр дүнгийн гэрээ, түүний гүйцэтгэл, тайлагналтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

1.5. Энэ хуульд заасан ил тод байдалтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамаарах төсөвт болон энэ хуулийн 1.4-т заасан гүйцэтгэх ажилд хамаарахгүй.

1.6. Төсвийн харилцааг зөвхөн энэ хуулиар зохицуулна.

**дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо**

1.7. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

“төсвийн тусгай шаардлага” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасныг;

“дунд хугацаа” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.9-д заасныг;

“дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.10-д заасныг;

“төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг хариуцлага, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг;

“улсын төсөв” гэж Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар ба улсын төсөвт харъяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

“суурь түвшинд үндэслэсэн төсөв” гэж макро эдийн засгийн таамаглалд нийцүүлж, тухайн төсөв хэрэгжих жилд хууль тогтоомж, эсхүл төрийн бодлогод өөрчлөлт орохгүй байхаар тооцсон төсвийн тооцоог;

“жилийн төсвийн хязгаар” гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг;

“төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг;

“төсвийн зарлага” гэж төсөв захирагчдын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг;

“төсвийн тэнцэл” гэж тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүүг;

“төсвийн ашиг” төсвийн зарлагаас давсан орлогыг;

“төсвийн алдагдал” гэж төсвийн орлогоос давсан зарлагыг;

"орлого" гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гаднаас хүлээн авах бүх төрлийн гүйлгээг;

"зарлага" гэж тухайн этгээдийн дотоод гүйлгээнээс бусад гадагш чиглэсэн бүх төрлийн гүйлгээг;

“хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэгдсэн багц арга хэмжээг;

“арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг;

“орц” гэж тухайн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах эдийн болон эдийн бус хөрөнгийг;

“эдийн засгийн томсгосон ангилал” гэж эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалын хэд хэдэн зүйлийг нэгтгэн бүлэглэснийг;

“эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал” гэж эдийн засгийн ангилалын анхдагч зүйлийг;

“санхүүгийн дэмжлэг” гэж төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор олгох хөрөнгийг;

“орлогын шилжүүлэг” гэж орон нутгийн төсвийг дэмжих зорилгоор улсын төсвийн орлогоос орон нутгийн төсөвт тооцож олгох хөрөнгийг;

“тусгай зориулалтын татаас” гэж доод шатны төсвөөс хэрэгжүүлэх хөтөлбөрийн зарим хэсгийг санхүүжүүлэх зорилгоор дээд шатны төсвөөс тусгай тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу олгох хөрөнгийг;

"хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

“татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг;

“төсвийн тодотгол” гэж эрх бүхий байгууллагын тухайн төсвийг баталсан шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулахыг;

“орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт хамаарах ерөнхийлөн захирагчдын бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг;

“орон нутгийн төсвийн суурь орлого” гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг;

“орон нутгийн төсвийн суурь зарлага” гэж энэ хуулийн 1.214, 1.215-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, 1.214, 1.214, 1.215, 1.215-д заасан чиг үүрэгтэй холбогдох урсгал зарлагын нийлбэрийг;

“орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн алдагдал” гэж орон нутгийн төсвийн суурь орлогоос давсан суурь зарлагыг;

“Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэж Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулагдах тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг;

"Хүний хөгжил сангийн төсөв” гэж Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулагдах тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг

"төсвийн байгууллага" гэж батлагдсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1.3-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

“төсвийн ерөнхийлөн захирагч” гэж өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

“төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

“төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

"төрийн чиг үүрэг хамаарах ажил, үйлчилгээг гүйцэтгэгч" гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж, тухайн үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээдийг;

“төрийн сангийн үйл ажиллагаа” гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг;

"төрийн сангийн нэгдсэн данс" гэж Засгийн газрын нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн ерөнхий данс болон Монгол Улсын нэгдсэн төсөвт хамаарах бүх төсвийн захирагчдын Монголбанкинд байрших мөнгөн хөрөнгийн харилцах дансдыг;

"төсвийн ерөнхий данс" гэж тухайн шатны төсвийн мөнгөн гүйлгээг нэгтгэн бүртгэх харилцах дансыг;

“зарцуулалтын эрх” гэж батлагдсан төсвийн хүрээнд төсвийн байгууллагын сар, улиралд зарцуулах төсвийн дээд хязгаарыг;

“Засгийн газрын өрийн удирдлага” гэж Засгийн газрын дунд болон богино хугацааны санхүүгийн зардал болон эрсдлийн түвшинг тодорхойлох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

“улсын өр” гэж Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг;

“болзошгүй өр төлбөр” гэж Засгийн газрын гаргасан баталгааг хангах, эсхүл үндэсний аюулгүй байдал, улс төр, нийгэм, эдийн засаг, санхүү төсвийн тогтворжилтыг хангах зорилгоор төрөөс хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээтэй холбогдон төсөвт үүсч болзошгүй эрсдлийг мөнгөн дүнгээр тооцож илэрхийлснийг;

“дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг;

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## Төсвийн зарчим, түүнийг хэрэгжүүлэх

### дугаар зүйл. Төсвийн зарчим

1.8. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална:

төсвийн тогтвортой байдлыг хангасан байх;
төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;
санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;
ил тод байдлыг хангасан байх;
хариуцлагатай байх.

### дугаар зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх

1.9. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагчид нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

1.10. Энэ хуулийн 1.8-д заасан төсвийн тогтвортой байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хэрэгжүүлэх;

жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх эх үүсвэр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;

урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээс төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсвэл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;

Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага,Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэх.

1.11. Энэ хуулийн 1.8-т заасан төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах;

санхүүгийн аливаа үйл ажиллагааг Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах;

төсвийн орлогоор баталгаажиж, түүгээр ирээдүйд санхүүжүүлэх төрөөс хэрэгжүүлэх баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэг хариуцлага бүхий үйл ажиллагааг төсөвт тусгах;

төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх.

1.12. Энэ хуулийн 1.8-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагын зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

төрийн чиг үүрэгт хамаарахгүй эсхүл арилжааны хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;

иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах;

хуульд өөрөөр заагаагүй бол аливаа бараа, ажил, үйлчилгээг нийлүүлэх, гүйцэтгэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;

төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх;

хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд эсвэл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх;

төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалтэсвэл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй хойч үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх;

төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;

1.13. Энэ хуулийн 1.8-т заасан төсвийн ил тод байдлын зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй эсэхэд олон нийтээс хяналт тавих боломжоор хангах;

төрөөс үзүүлж буй аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээнд олон нийтээс хяналт тавих боломжоор хангах;

хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замын талаарх шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

төсвийн талаарх олон нийтийн санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгахаа бие даан шийдвэрлэх.

1.14. Энэ хуулийн 1.8-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсвэл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;

төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харъяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;

төсвийн захирагч нь өөрийн эрх, үүргээ доод шатны төсвийн захирагчид шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;

төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх;

тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосончиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжүүлтээр хэрэгжүүлэх;

**дугаар зүйл. Төсвийн жил**

1.15. Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

1.16. Төсвийн жил нь сар, улирал, хагас жил, бүтэн жил гэсэн үеүүдэд хуваагдана.

1.17. Төсвийг нэг жилээр батлаж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжүүлнэ.

1.18. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.

1.19. Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталсан өдрөөс эхлэн зохион байгуулж болно.

1.20. Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ.

1.21. Энэ хуулийн 1.153 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

1.22. Салбарын үйл ажиллагааны онцлогоос хамаарч төсвийн хэрэгжилтийн хугацаа нь төсвийн жилээс зөрүүтэй бол төсвийн төлөвлөлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу зохицуулна.

**дугаар зүйл. Төсвийн цаглабар**

1.23. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт хүргүүлнэ.

Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 1-ний өдрийн дотор хэлэлцэж, батална.

Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш ажлын 7 хоногийн дотор хэвлэн нийтлэнэ.

1.24. Төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарыг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ;

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарын төслийг нэгтгэн боловсруулж жил бүрийн 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор Засгийн газарт хүргүүлнэ;

Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор батална.

1.25. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн  жилийн төсвийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

төсвийн төвлөрүүлэн захирагчид харъяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор харъяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ;

төсвийн төвлөрүүлэн захирагч болон түүнд харъяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;

төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жилийн төсвийн төслийг нэгтгэн боловсруулж жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засгийн газарт өргөн мэдүүлнэ;

Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ;

Засгийн газар төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнээс хойш ажлын 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ;

төрийн аудитын төв байгууллага жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ;

Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батална;

1.26. Аймаг, нийслэлийн жилийн төсвийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ;

аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор батална;

сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ;

сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор батална;

аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн батлагдсан төсвийг 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

1.27. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч төсвийн хуваарийн саналаа жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;

төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн хуваарийн саналаа жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төвлөрсөн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн жилийн төсвийн хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрийн дотор батална.

1.28. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор батална;

аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

1.29. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сан, аймаг, нийслэлийн төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална:

төсвийн шууд захирагч төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны өдрийн дотор харъяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ;

төсвийн төвлөрүүлэн захирагч, тусгай сан төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 4-ний өдрийн дотор харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;

төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 6-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 8-ны өдрийн дотор батална;

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сар, улирлын батлагдсан гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 15-ны өдрийн дотор олон нийтэд хэвлэн мэдээлнэ.

1.30. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, орон нутгийн жилийн төсвийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглабарын дагуу боловсруулна:

төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор гаргаж харъяалах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудитлагдсан санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор харъяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ;

төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудитлагдсан тайланг 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;

орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 35.1-д заасан байгууллагын хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 7 дугаар 25-ны өдрийн дотор харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудитлагдсан тайланг 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ;

төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудитлагдсан тайланг 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төрийн төв аудитын байгууллагад хүргүүлнэ.

1.31. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглабарын дагуу боловсруулна:

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 5 дугаар сарын 10-ны өдрийн дотор төрийн төв аудитын байгууллагад хүргүүлнэ.

төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг 1 сарын дотор аудит хийж Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлнэ.

Засгийн газар энэ хуулийн 8.9.2-т заасан аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг намрын чуулганаар хэлэлцэн батална.

санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн гүйцэтгэл болон аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланг олон нийтэд хэвлэн мэдээлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## Төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтаны бүрэн эрх

### дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

1.32. Улсын Их Хурал төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг батлах;

дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж жил бүр улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, тэдгээрийн тодотголыг батлах;

нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх;

улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж, батлах;

төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих;

Засгийн газрын үнэт цаас гаргах зөвшөөрөл олгох.

**дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

1.33. Засгийн газар төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар батлах;

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл,жилийн төсвийн төсөл, тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг батлах;

төсвийн байгууллагын орон тоог төсвийн эрх захирагч бүрээр батлах;

төсвийн төсөл нь энэ хуулийн 1.100 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах;

төсвийн хэрэгжилтэд хяналт тавих;

нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд тайлагнах;

Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Засгийн газрын үнэт цаас гаргах;

Улсын Их Хурлын шийдвэрээр байгуулахаар хуульд зааснаас бусад улсын төсөвт байгууллагыг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах;

төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах;

Засгийн газрын зээл болон улсын өрийн удирдлага, түүний стратегийг тодорхойлж, хэрэгжүүлэх;

улсын хөрөнгө оруулалтын арга хэмжээний төслийг боловсруулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг батлах;

тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж оруулахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх.

**дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

1.34. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл болон жилийн төсвийн хязгаарыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах;

төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтэц, орон тооны нормативыг тогтоох;

төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

төсвийн дэлгэрэнгүй ангиллыг батлах;

Засгийн газраас эрх олгосноор зохих хууль, тогтоомжид заасны дагуу Засгийн газрын нэрийн өмнөөс зээл авах буюу зээл авах зөвшөөрөл олгох, зээлийн баталгаа гаргах;

төсөв, татвартай холбоотой хуулийн төсөлд төсөв, санхүүгийн бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

зээл, тусламжийн удирдлагыг хэрэгжүүлэх;

өрийн удирдлага, түүний стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх;

төрийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах;

төсөв санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангах;

төсвийн гүйцэтгэлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

төсвийн сар, улирлын хуваарийг батлан мөрдүүлэх, өөрчлөлт оруулах;

энэ хуулийн 1.33-д заасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох;

төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох;

төрийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох;

орон нутгийн төсвийг боловсруулах журмыг батлах;

Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг тогтоох;

энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг төсвийн байгууллага, бусад этгээдээс гаргуулж авах;

**дугаар зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

1.35. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон түүнд тусгах эдийн засаг, төсвийн таамаглалыг боловсруулах;

эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн төсөл, тэдгээрийн тодотголын төслийг боловсруулах;

Улсын Их Хурлаас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр жилийн төсвийн хязгаар боловсруулах;

тухайн төсөв хэрэгжих жилийн төсөв боловсруулах удирдамжийг төсвийн цаглабарыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

төсвийн тодотгол хийх тухай Засгийн газрын саналыг боловсруулах;

төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;

нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах;

Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргах;

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

Засгийн газрын үнэт цаасны болон зээлийн нөхцөлийг өөрчлөх, зээл төлөх санал боловсруулах;

улсын төсвийн байгууллагад банкинд данс нээх зөвшөөрөл олгох;

улсын төлөгдөөгүй өрийн үлдэгдэл, дунд хугацаан дахь өрийн үйлчилгээний таамаглалыг хагас жил тутам гаргаж хэвлэн нийтлэх;

төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгө, нөөцийн санг байршуулах;

эдийн засаг, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсвийн байгууллагын арга хэмжээний гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгөөр орон нутгийн байгууллагаас худалдан авах арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт тавих;

төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх,

төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох;

төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур арилжааны банкинд данс нээх зөвшөөрөл олгох, зөвшөөрөлгүй нээсэн дансыг хаалгах;

төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг бууруулах;

эдийн засаг, санхүү, төсвийн бодлогын шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулах;

төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтын мэдээллийн нэгдсэн тогтолцоог удирдах;

энэ хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг төсвийн байгууллага, бусад этгээдээс гаргуулж авах.

**дугаар зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх**

1.36. Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ерөнхийлөгчийн төсвийн;

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын болон Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг ба удирдлагыг нь Улсын Их Хурал томилдог байгууллагын төсвийн;

Ерөнхий сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн;

Тэргүүн шадар сайд түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан байгууллагын төсвийн;

Шадар сайд түүнд хууль тогтоомжоор харьялуулсан байгууллагын төсвийн;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын төсөв, Тэргүүн шадар сайд, Шадар сайдын ажлын албаны төсөв, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөв болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;

Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн;

Үндсэн хуулийн цэцийн дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн;

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шүүхийн төсвийн;

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн төсвийн;

Улсын ерөнхий прокурор прокурорын байгууллагын төсвийн;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга тус зөвлөлийн;

аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон түүнд ажлаа шууд тайлагнадаг ба удирдлагыг нь шууд томилдог байгууллагын төсвийн;

аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн төсвийн.

1.37. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах;

эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан, санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах;

хөтөлбөрийн үр дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах;

хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжиж дууссаны дараа хөрөнгийн зарцуулалтын үр дүнг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

1.38. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрийн төсвийн гүйцэтгэлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар болон Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.

1.39. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч эсхүл харъяа шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

1.40. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх төсвийн асуудлыг хариуцан гүйцэтгэх санхүүгийн нэгж, нягтлан бодогч, ажилтантай байна.

**дүгээр зүйл. Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний бүрэн эрх**

1.41. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харъяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно.

1.42. Энэ хуулийн 1.131-д зааснаар гэрээгээр шилжүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

1.43. Улсын төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харъяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно.

1.44. Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харъяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 1.37, 1.37, 1.37, 1.37–д заасан төсвийн ерөнхийлөн захирагчийн болон энэ хуулийн 1.48-д заасан төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлнэ.

Энэ хуулийн 1.37-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

**дугаар зүйл.Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх**

1.45. Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна.

1.46. Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагчийг Улсын Их Хурал тогтооно.

1.47. Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Тамгын газрын төсвийн;

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын төсвийн;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ерөнхий сайдын төсвийн, Тэргүүн шадар болон Шадар сайдын ажлын албаны, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн;

төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга тус байгууллагын төсвийн;

агентлагийн дарга тус агентлагийн төсвийн;

Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга тус зөвлөлийн төсвийн;

Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга тус шүүхийн төсвийн;

Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн нарийн бичгийн дарга Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны төсвийн;

аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүхийн тамгын хэлтсийн дарга тухайн шатны шүүхийн төсвийн;

Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга Улсын ерөнхий прокурорын газрын төсвийн;

аймаг, нийслэлийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга тухайн шатны прокурорын байгууллагын төсвийн;

аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн;

аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргын Тамгын газрын төсвийн;

Засгийн газрын шугамаар авч байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн нэгжийн дарга тухайн төслийн төсвийн;

Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн.

төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн;

1.48. Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;

батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд хяналт тавих;

батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;

санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөх;

**дугаар зүйл. Төсвийн байгууллага**

1.49. Санхүүжилт нь төсөвт батлагдаагүй хуулийн этгээд болон нэг удаагийн шинж чанартай байнгын бус үйл ажиллагаа явуулах, төсвийн захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгж нь түүнийг шууд харъяалах төсвийн эрх захирагчид харъяалагдаж төсвийн харилцаанд оролцоно.

1.50. Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна.

1.51. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу төсвийн байгууллагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.

**дугаар зүйл. Тусгай сан**

1.52. Төрийн зарим чиг, үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгай сангаар дамжуулан гүйцэтгэж болно.

1.53. Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, Орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна.

1.54. Засгийн газрын тусгай санг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, орлого болон зарцуулалтын талаархи харилцааг хуулиар зохицуулна.

1.55. Орон нутгийн тусгай санг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, орлого болон зарцуулалтын талаархи харилцааг энэ хуулиар зохицуулна.

1.56. Засгийн газрын тусгай сан нь улсын төсвийн, орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

**дугаар зүйл. Төсвийн ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх**

1.57. Бүх шатны төсөв нь тухайн шатны төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна.

1.58. Энэ хуулийн 1.36, 1.36, 1.36, 1.36, 1.36, 1.36-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн ерөнхий нягтлан бодогчтой байна.

1.59. Энэ хуулийн 1.57-д зааснаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогч, нягтлан бодогчтой байна.

1.60. Энэ хуулийн 1.36, 1.36, 1.36, 1.36, 1.36-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн ерөнхий нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

1.61. Сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчтай, аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

1.62. Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогчийг дараах байдлаар зөвшилцөн томилж, чөлөөлнө:

улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, хүний хөгжлийн сангийн төсөвт харъяалагдах төвлөрүүлэн болон шууд захирагчийн нягтлан бодогчийг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн даргатай;

энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан гэрээгээр орон нутагт шилжүүлсэн төсвийн төвлөрүүлэн захирагчид харъяалагдах төсвийн байгууллагын ахлах нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төрийн сангийн хэлтсийн даргатай.

аймаг, нийслэлийн төсөвт харъяалагдах төвлөрүүлэн болон шууд захирагчийн, сумын төсөвт харъяалагдах шууд захирагчдын нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай;

дүүргийн төсөвт харъяалагдах шууд захирагчийн нягтлан бодогчийг, дүүргийн санхүү, төрийн сангийн хэлтэсийн даргатай;

**дүгээр зүйл. Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо**

1.63. Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ.

1.64. Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоон дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна.

1.65. Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## Төсвийн бүтэц

**дүгээр зүйл. Төсвийн шатлал**

1.66. Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвөөс бүрдэнэ.

1.67. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

1.68. Аймаг, нийслэлийн төсвийн дээд шатны төсөв нь улсын төсөв, сум, дүүргийн төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв байна.

1.69. Төсвийн шатлал бүрт ногдох орлого, хэрэгжүүлэх чиг үүргийг хуулиар тогтооно.

**дугаар зүйл. Төсвийн ангилал**

1.70. Төсвийг тогтоосон ангилалын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэж, тайлагнана.

1.71. Төсвийг дор дурдсаны дагуу ангилна:
төсвийн шатлалаар;
төсвийн захирагчаар;
эдийн засгийн ангиллаар;
хөтөлбөрөөр;
арга хэмжээгээр;
санхүүжүүлэх эх үүсвэрээр;

1.72. Энэ хуулийн 1.71-д заасан төсвийн эдийн засгийн ангилал дор дурьдсан дэд ангилалтай байна:
орлого;
зарлага;
тайлан тэнцэл;
нэмэлт мэдээлэл.

1.73. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үе шат бүрт төсвийн ангиллыг дараах байдлаар хэрэглэнэ:
дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийг төсвийн шатлал бүрээр тогтоох;
төсвийн зарлагын дээд хязгаарыг төсвийн шатлал, тэдгээрт харъяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр, зарлагын томсгосон ангиллаар тогтоох;
төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангилалын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангилалын дагуу бэлтгэх;
төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харъяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр, хүрэх үр дүнгийн хамт баталдаг байх;
төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төвлөрүүлэн захирагч бүрээр, төвлөрүүлэн захирагчид харъяалагдахгүй төсвийг шууд захирагч бүрээр энэ хуулийн 1.71-1.71-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт баталдаг байх;
төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг шууд захирагч бүрээр, энэ хуулийн 1.71-1.71-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт баталдаг байх;
төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 1.71-1.71-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнадаг байх;

төсвийн гүйцэтгэлийн явцын хяналтыг энэ хуулийн 1.71-д заасан ангиллаар хийх бөгөөд эдийн засгийн дэлгэрэнгүй ангилалын дотор томсгосон ангилалаар хяналтын түвшинг тогтоож болно.

1.74. Төсвийн байгууллагын орон тоо зэрэг төсвийн орцын мэдээлэл, болзошгүй өр төлбөр зэрэг нягтлан бодох бүртгэлээр хүлээн зөвшөөрөгдөөгүй мэдээллийг энэ хуулийн 1.72-д заасан ангиллалд хамааруулна.

1.75. Төсөв батлах болон хэрэгжүүлэхэд энэ хуулийн 1.72-д заасан ангиллаар нэмэлт хяналт тогтоож болно.

1.76. Энэ хуулийн 1.71-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

1.77. Төсвийн ангилалыг Засгийн газрын санхүүгийн статистикийн Олон улсын стандартуудад нийцүүлэн хөрвүүлэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

1.78. Энэ хуулийн 1.73-д заасан ангиллаар тогтоосон төсвийг зүйл хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг төсвийн эрх захирагчийн ангилал бүрээр тогтоох, томсгосон хяналтын түвшинг тогтоох нийтлэг журмыг Засгийн газар тогтоон мөрдүүлнэ.

**дүгээр зүйл. Төсвийн орлого**

1.79. Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлого, бусад орлогоос бүрдэнэ.

1.80. Татварын орлого нь Татварын ерөнхий хуулиар тогтоосон албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

1.81. Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр,түүнийг борлуулсны орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, гадаад орон болон Олон улсын байгууллагаас авсан зээл, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ.

1.82. Улсын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:
аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
нэмэгдсэн өртгийн албан татвар;
онцгой албан татвар;
гаалийн албан татвар;
автобензин, дизелийн түлшний албан татвар;
ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
ашигт малтмалын хайгуулын болон ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн төлбөр;

1.83. Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:
төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого;

хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх бусад орлого.

1.84. Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

хотын оршин суугчийн албан татвар;
хот төлөвлөлтийн албан татвар;
газрын төлбөр;
үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;
авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар.
цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар.

1.85. Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого дараахь орлогоос бүрдэнэ:

орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;
хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт орох бусад орлого.

1.86. Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар;
бууны албан татвар;
улсын тэмдэгтийн хураамж;
агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;
байгалийн баялаг ашиглахад олгох зөвшөөрлийн хураамж;
байгалийн ургамал ашигласны төлбөр;
ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;
түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;
ус, рашаан ашигласны төлбөр;
орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар.

1.87. 10.4. Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараахь орлогоос бүрдэнэ:

орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;
хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого.

1.88. Төсөвт болон төсвийн байгууллагын авсан хандив, тусламж, дэмжлэгийн орлого нь төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байна.

1.89. Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төсвийн төслийн хамт урьдчилан тооцоолж мэдээлэх ба төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана.

**дугаар зүйл. Төсвийн зарлага**

1.90. Төсвийн зарлага нь урсгал зардал, хөрөнгийн зардлаас бүрдэнэ.

1.91. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйчилгээг худалдан авах ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

1.92. Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харъяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээ нь тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамрагдсан байна.

1.93. Тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад төсвийн зарлагыг дараах байдлаар хуваарилна:

боловсролын салбарт улсын төсвийн орлогын 20 хувиас доошгүйг;

шинжлэх ухаан, технологийн салбарт Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувьтай тэнцэх хэмжээг;

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төсвийн орлогын 0,3 хувиас доошгүйг;

малчдад үзүүлэх төрийн үйлчилгээ, мал хамгаалах, бэлчээрийн менежментийг сайжруулах үйл ажиллагаанд улсын төсвийн орлогын 3 хувиас доошгүйг;

**дугаар зүйл. Тусламжийн орлого, түүгээр санхүүжих зарлага**

1.94. Төсвөөс нэмэгдэл эх үүсвэр шаардагдах тусламжийг тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллагаас зөвшөөрөл олгосны дагуу авна.

1.95. 500 сая төгрөгөөс дээш үнэ бүхий хувьцаа, өрийн бичиг,үндсэн хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хандив, тусламжаар авахдаа Засгийн газрын зөвшөөрөл авна.

1.96. Төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээнд тавигдах шаардлага тусламжийн орлогоос санхүүжүүлэх үйл ажиллагаанд нэгэн адил хамаарна.

1.97. Монгол Улсын Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тусламжийн орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулна.

**дүгээр зүйл. Санхүүгийн бүртгэл, стандарт**

1.98. Төсвийн байгууллага нь Монгол улсын болон Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нагтлан бодох бүртгэл хөтөлнө.

1.99. Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж тайлагнана.

1.100. Улсын салбар, төсвийн бүртгэлд ашиглах нягтлан бодох бүртгэлийн үндэсний стандартыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулж, мөрдүүлнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## Төсвийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах

**дугаар зүйл. Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага**

1.101. Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана:

төсвийн зарчмуудыг мөрдлөг болгох;

макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;

төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх;

төсвийн төслийг хөтөлбөр, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр тодорхойлсон байх;

төсвөөс санхүүжих бүх байгууллагын төсвийг аль нэг ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд хамруулсан байх.

орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнана.

**дугаар зүйл. Төсвийн хөрөнгө оруулалт**

1.102. Төсөвт төлөвлөгдөж, батлагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дараах шаардлага тавигдана:

тухайн салбарын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан, нийгэм, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээг санал болгосон байх;

техник, эдийн засгийн үндэслэл болон бусад тооцоо судалгаагаар эдийн засгийн болон нийгмийн үр ашигтай байдлыг нь нотолсон байх;

нийт төсөвт өртөг нь 30 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хувьд түүний техник, эдийн засгийн үндэслэлийг эдийн засгийн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас судалж, үр ашигтай байдлыг нь тогтоосон байх;

концессийн гэрээгээр хэрэгжүүлэх боломжгүй;

шинээр баригдах барилга, байгууламжийн судалгаа, зураг төсөл, төсвийг батлуулсан, магадлал хийлгэсэн байх;

газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл бүрдсэн байх;

хөрөнгө оруулалтын үр дүнд бий болох үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хийж, төсөвт нөлөөлөх ачааллын талаар дүгнэлт гаргасан байх;

төсөл, арга хэмжээний нийт саналыг ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллаар нь эрэмбэлж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтсан хэсгийг тусгах;

хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн салбарын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт харъяалуулах;

шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилснаас багагүй байх.

1.103. Энэ хуулийн 1.102-д заасан судалгаа нь дараах төсөл, арга хэмжээнд хамаарахгүй:

үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалахтай холбогдсон төсөл, арга хэмжээ;

байгалийн гамшигаас үүдэлтэй нөхөн сэргээлттэй холбогдсон төсөл, арга хэмжээ.

1.104. Энэ хуулийн 1.102-д заасан үр ашигтай байдлыг нь тогтоох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

1.105. Санхүүжүүлэх эх үүсвэрээс нь үл хамааран хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүрэн хэмжээгээр нь төсөвт тусган батална.

1.106. Батлагдсан төсөвт өртгийг дараах тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган өөрчилж болно:

байгалийн болон давагдашгүй хүчин зүйл нөлөөлсөн;

үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс 2 дахин өссөн;

1.107. Гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хамаарч энэ хуулийн 1.106-т заасан нөхцөл байдал үүссэн нь төсөвт өртгийг өөрчлөх үндэслэл болохгүй.

**дугаар зүйл. Хөрөнгө оруулалтыг төлөвлөх**

1.108. Төсвийн ерөнхийлөн захирагч нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг түүний ач холбогдлоор нь эрэмблэн, санхүүжүүлэх эх үүсвэрийг нь тодорхойлж боловсруулсан жагсаалт, холбогдох тооцоолол болон бичиг баримтын хамт тухайн шатны эдийн засгийн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.

1.109. Энэ хуулийн 1.108-д заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг энэ хуулийн 1.110-д заасан ач холбогдлыг харгалзан эрэмбэлж, холбогдох тооцооллын хамт тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллагад хүргүүлнэ.

1.110. Дараах ач холбогдлыг харгалзан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт тусгана:
улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого;
Засгийн газрын үйл ажиллаганы хөтөлбөр, тэргүүлэх чиглэл;төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний нэгдсэн стандарт;
нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
салбарын хөгжлийн бодлого;
бүс нутгийн хөгжлийн бодлого;
орон нутгийн хөгжлийн индекс.

1.111. Энэ хуулийн 1.109-д заасан жагсаалтад үндэслэн улсын хөрөнгө оруулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулна.

**дугаар зүйл. Төр болон хувийн хэвшлийн түншлэл**

1.112. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийн дараах хэлбэрүүд байна:
төрийн үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;
концессын гэрээгээр;

1.113. Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг дараах тохиолдолд хэрэгжүүлнэ:
хувийн хэвшлийн эзэмшиж буй техник, технологи, үр ашигтай удирдлагын арга барилыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх;
хувийн хэвшил дангаараа хэрэгжүүлэх боломжгүй, төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;
төсөл арга хэмжээ нь эдийн засгийн хувьд үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэлээр нотлогдсон;

1.114. Төсвийн санхүүжилтийн дутагдлыг нөхөх, төсвөөс төлөх төлбөрийг хойшлуулах зорилгоор төр ба хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхийг хориглоно.

1.115. Концессийн гэрээгээр хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ нь төсвийн бүрэлдэхүүн байна.

1.116. Концессийн гэрээтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна.

**дүгээр зүйл. Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл**

1.117. Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:

санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;

хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;

жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;

эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

эрхлэх асуудлын хүрээнд төсвөөс санхүүжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;

худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

1.118. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 1.117-д заасан хязгаарт багтаагүй саналаа, төвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ.

1.119. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана:

төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо;

төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо;

шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тооцоо;

нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй болсон хөтөлбөр, арга хэмжээг зогсоох эсхүл санхүүжилтийг бууруулах санал, тооцоо;

төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо;

төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо.

1.120. Засгийн газар болон Засаг даргын зөвлөл нь төсвийн төслийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр хэлэлцэнэ.

**дугаар зүйл. Төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх**

1.121. Засгийн газар нэгдсэн төсөв, Нийгмийн даатгалын болон Хүний хөгжил сангийн төсвийн төслийг энэ хуулийн 1.122-д заасан танилцуулгын хамт энэ хуулийн 1.25-д заасан цаглабарын дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

1.122. Төсвийн төслийн танилцуулгад дараах зүйлийг тусгасан байна:

макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо;

макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас тухайн жилд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг төсвийн төсөлд тусгасан байдал;

төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал;

төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ;

төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл;

хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/;

санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар;

гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, обьект, үнийн дүнгээр/;

тусгай сангийн орлого, зарлагын тооцоо;

төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ;

төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга;

төсвийн тусгай шаардлагад болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцэж байгаа тайлбар;

төсвийн тусгай шаардлагыг түр баримтлахгүй тохиолдолд түүний үндэслэл, санал;

нэгдсэн төсвийн орлого, зарлагын үзүүлэлтүүдийн хураангуй тайлбар;

төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон байдал;

төсөв алдагдалтай төлөвлөгдсөн бол уг алдагдлыг санхүүжүүлэх тухай санал;

Засгийн газрын зээлийн үлдэгдэл, төслийн зээлийн дотоод эх үүсвэрийн хэмжээ, Засгийн газраас гаргасан баталгаа, түүний дүн;

нэгдсэн төсвийн орлогын 1 хувиас хэтэрсэн дүнтэй тэнцэх болзошгүй өр төлбөр, түүний учирч болзошгүй эрсдэлийн тооцоо;

төсвийн төсөлтэй холбогдуулан шийдвэрлүүлэх хууль, тогтоомжийн төсөл.

**дүгээр зүйл. Улсын Их Хурал төсөв батлах**

1.123. Улсын Их Хурал Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан улсын төсөв, Нийгмийн даатгалын болон Хүний хөгжил сангийн төсвийн төслийг энэ хуулийн 1.25-д заасан цаглабарын дагуу хуульчилан батална.

1.124. Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:

төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилд харъяалагдах шатны төсөвтөө төвлөрүүлэх орлого, харъяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;

төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ;

төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;

бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;

хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, тэдгээрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;

нийслэл, хотын хөгжлийн хэрэгцээнд зориулж улсын төсвөөс олгох хөрөнгө оруулалтын тусгай зориулалтын татаасын зориулалт, зарцуулалтын нөхцөл, шаардлагыг хавсралтаар;

концессийн гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцлийг хавсралтаар;

**дугаар зүйл. Тодотгол**

1.125. Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал үүссэн;

урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиар нэмэгдэх;

хуулийн 1.106-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах;

1.126. Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ:

дээд шатны төсөвт тодотгол хийсэний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон

урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон, энэ хуулийн 1.106-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах;

1.127. Энэ хуулийн 1.125, 1.126-д заасан үндэслэлээр тухайн жилийн төсөвт тодотгол хийж дуусах хүртэл хугацаанд санхүүжүүлэх хэмжээ нь багасахаар эсхүл хасагдахаар төсвийн тодотголийн төсөлд тусгагдсан бөгөөд гэрээ байгуулагдаагүй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийг түр зогсоож болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## Төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл

### дугаар зүйл. Төрийн сангийн үйл ажиллагаа

1.128. Төрийн сангийн үйл ажиллагааг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар эрхлэн гүйцэтгэнэ.

1.129. Төрийн сангийн үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

төсвийн гүйлгээг төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэх

төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх;

төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх;

төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;

төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж, хяналт тавих;

төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг бүртгэх, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх;

төсвийн орлогын дутагдлыг нөхөх зорилгоор төрийн сангийн нэгдсэн дансны хүрээнд тухайн жилийн эцэст хаагдсан байхаар богино хугацааны өглөг үүсгэн санхүүжүүлэх;

төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох, бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх;

мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг үр ашигтайгаар байршуулах;

1.130. Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

### дүгээр зүйл. Улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээ

1.131. Энэ хуулийн 1.36, 1.36-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн шинж чанартай үйлчилгээ үзүүлж байгаа төсвийн байгууллагын төсвийн урсгал зардлыг хуваарилан зарцуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад энэ хуулийн 1.136 дугаар зүйлд заасан гэрээгээр шилжүүлнэ.

1.132. Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 1.131-д заасан гэрээний үндсэн дээр сум, дүүрэгт харъяалагдах төсвийн байгууллагын төсвийг сум дүүргийн Засаг даргад энэ хуулийн 1.136 дугаар зүйлд заасан гэрээгээр шилжүүлнэ.

1.133. Сум дүүргийн Засаг дарга энэ хуулийн 1.132-т заасан гэрээний үндсэн дээр төсвийн байгууллагын санхүүжилтийг хуваарилна.

1.134. Энэ хуулийн 1.132, 1.133-т заасан гэрээний дагуу төсвийг хуваарилахдаа төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг хөтөлбөр хооронд болон бусад ерөнхийлөн захирагчийн төсөвт шилжүүлэхийг хориглоно.

1.135. Энэ хуулийн 1.131-1.133-т заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, Засгийн газарт танилцуулна.

1.136. Энэ хуулийн 1.131-д заасан орон нутгийн шинж чанартай үйлчилгээ үзүүлж байгаа төсвийн байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.

**дугаар зүйл. Үр дүнгийн гэрээ**

1.137. Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нь харъяалах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна.

1.138. Үр дүнгийн гэрээнд байгууллагын төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, тэдгээрийн төсөв, хүрэх үр дүн, түүнийг дүгнэх талаар тусгасан байна.

1.139. Үр дүнгийн гэрээний биелэлтийг харъяалах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

1.140. Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн гэрээг дүгнэгч этгээд нь дараах арга хэмжээг авна:

төсвийн үр дүнг сайжруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар үүрэг өгч, хянаж ажиллах;

хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох;

**дугаар зүйл. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах**

1.141. Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулал болон бүрдүүлэлтэд тавигдах хяналтыг төсвийн сар, улирлын хуваариар баталж хэрэгжүүлнэ.

1.142. Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:

хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

төсвийн гүйцэтгэлийг хууль, тогтоомжийг дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах;

энэ хуулийн 1.35-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;

төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

1.143. Төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллагаас баталж мөрдүүлнэ.

1.144. Төсвийн жил эхлэхэд төсөв батлагдаагүй байх нөхцөл байдал үүсвэл төсөв батлагдах хүртэл төсвийн санхүүжилтийн түр горим тогтоож, төсвийн зарлагыг дараах байдлаар санхүүжүүлнэ:

төсвийн байгууллагад ажиллагсадын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр;

нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг доод хэмжээгээр;

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгийг өмнөх оны түвшинд;

батлан хамгаалах, хил хамгаалах, дотоодын цэрэг, үндэсний аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд, онцгой байдал, шүүх эрх мэдэл, прокурорын байгууллага, цагдаа, татвар, гааль, мэргэжлийн хяналт, төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал зардлыг өмнөх оны түвшинд;

энэ хуулийн 1.144-т зааснаас бусад төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны урсгал төсвийг тэдгээрийн өмнөх оны урсгал төсвийн 50 хувиар;

Засгийн газрын зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг уг зээлийн гэрээнд заасан хугацаа, төлбөрийн хэмжээг баримтлан.

1.145. Доод шатны төсөвт хамаарах үйл ажиллагааны энэ хуулийн 1.144-д заасан санхүүжилтийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор дээд шатны төсвөөс богино хугацааны зээл олгож болно.

1.146. Энэ хуулийн 1.144-д заасан түр горимыг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх төсвийн сар, улирлын хуваарийг тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллага батлаж, мөрдүүлнэ.

**дугаар зүйл. Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх**

1.147. Төсвийн ерөнхийлөн захирагч хоорондын төсвийн зохицуулалтыг зөвхөн тухайн жилийн төсөвт тодотгол хийж шийдвэрлэнэ.

1.148. Төсвийн ерөнхийлөн захирагч нь хөтөлбөр хооронд түүнчлэн түүнд шууд харъяалагдах төвлөрүүлэн болон шууд захирагчдын төсөв хооронд, төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах шууд захирагчдын төсөв хооронд, шууд захирагч нь зөвхөн үйл ажиллагааны зардалд зохицуулалт хийж болно.

1.149. Төсвийн шууд захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харъяалах төвлөрүүлэн захирагчид, төвлөрүүлэн захирагчид харъяалагддаггүй бол төсвийн ерөнхийлөн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч нь харъяалах ерөнхийлөн захирагчид, төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллагад тус тус хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

1.150. Тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг хянаж, төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ.

1.151. Энэ хуулийн 1.42-д заасан төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харъяалагдах төсвийн шууд захирагчдын төсөвт зохицуулалт хийх асуудлыг өөрийн баталсан төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэнэ.

1.152. Төсөв захирагчийн төсөвт зохицуулалт хийх хязгаар, нөхцөл, журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.153. Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

**дугаар зүйл. Төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт**

1.154. Төсөл, арга хэмжээний онцлогоос шалтгаалан түүнийг хэрэгжүүлэх мөчлөг нь төсвийн жилээс зөрүүтэй бол дараах төсөл, арга хэмжээний тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилд үргэлжлүүлэн хэрэгжүүлж болно:

Засгийн газрын өрийн бичиг, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр;

хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв;

Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон Олон улсын байгууллагын хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв;

төсвийн урамшуулал;

төсөвт хамаарахгүй этгээдээс авсан хандив, тусламж, дэмжлэг.

1.155. Зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилд дамжсан, энэ хуулийн 1.154-д зааснаас бусад төсвийн нийт дүн нь төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн 3 хувиас хэтрэхгүй бөгөөд илүүдэл хэсгийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

1.156. Төсвийн жил дуусахад Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан эргэлтийн сангийн үлдэгдэл хөрөнгийг төсөвт төвлөрүүлэхгүй бөгөөд тухайн хөрөнгийг дараагийн жилийн батлагдсан төсвийн дагуу зарцуулна.

1.157. Энэ хуулийн 1.154, 1.154-д зааснаас бусад төсвийн зарцуулах эрх нь хоёр төсвийн жил дамжин хэрэгжихгүй.

1.158. Энэ хуулийн 1.154-д заасан төсөв зарцуулах эрх нь дараагийн төсвийн жилийн 3 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд шилжинэ.

1.159. Төсөв зарцуулах эрхийг дараагийн төсвийн жилд шилжүүлсэн нь батлагдсан төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний тухайн жилд хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг бууруулах үндэслэл болохгүй.

**дүгээр зүйл. Туслах үйл ажиллагаа**

1.160. Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулан орлого олж болно:

төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн, уг үйл ажиллагаанаас алдагдал учирвал нөхөх төсвийн бус эх үүсвэрийг төлөвлөсөн байх;

санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан;

байгууллагын хөрөнгийг зориулалт бусаар ашиглаагүй, ажилтныг үүрэгт ажлаас нь хөндийрүүлээгүй;

туслах үйл ажиллагаа эрхлэх нь тухайн төсвийн байгууллагын чиг үүрэг, үндсэн үйл ажиллагаанд харшлахгүй.

1.161. Туслах үйл ажиллагааны зардалд тухайн үйл ажиллагааг эрхлэхтэй холбогдсон шууд болон шууд бус бүх төрлийн зардал, өглөг, санхүүгийн үүргийг оруулж тооцох бөгөөд үндсэн үйл ажиллагааны зардлаас шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно.

1.162. Туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

1.163. Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна:

тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах;

тухайн салбар болон байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт;

тухайн салбар болон байгууллагын ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

үлдэгдэл ашгийг төсвийн жилийн эцэст тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

1.164. Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашгаас энэ хуулийн 1.163, 1.163-д заасан асуудалд зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн 1.167 дүгээр зүйлд заасаны дагуу зохицуулна.

**дүгээр зүйл. Төсвийн зарлагын хэмнэлт**

1.165. Төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дараах нөхцөлд төсвийн зарлагын хэмнэлтэд тооцно:

урсгал төсвөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ нь буурсны улмаас бий болсон үлдэгдлийг;

төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлын үр ашгийг нэмэгдүүлж, чанарыг бууруулахгүйгээр нэгжид ногдох өртөг, зардлыг бууруулсанаас бий болох үлдэгдлийг;

нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааны чанарыг бууруулахгүйгээр нэгжийн өртөг, зардлыг бууруулсанаас бий болох үлдэгдлийг.

1.166. Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:

нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол;

төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсвэл тоо хэмжээ нь буурсанаас бий болсон үлдэгдэл;

хөрөнгө оруулалтын худалдан авах үйл ажиллагааны үед нэгжид ногдох өртөг, үнэ, тоо хэмжээ нь буурсанаас бий болсон үлдэгдэл;

төрийн захиргааны байгууллагын орон тоог нөхөн бүрдүүлэх үед гарсан цаг хугацааны алдагдлаас бий болсон үлдэгдэл;

**дүгээр зүйл. Төсвийн урамшуулал**

1.167. Төсвийн захирагчид туслах үйл ажиллагааны ашиг, төсвийн зарлагын хэмнэлт болон төсвийн захирагчийн чиг үүргийн дагуу төсөвт төвлөрүүлэх орлогыг давуулан биелүүлсэн үр дүнгийн гэрээний урамшууналыг тус тус олгож болно.

1.168. Энэ хуулийн 1.167-д заасан урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг тухайн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн дараа жилийн төсвийн багцад тусган баталж, түүний шийдвэрээр олгоно.

1.169. Төсвийн урамшуулал олгох хувь, хэмжээ, шалгуур үзүүлэлт, түүнийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.170. Төсвийн урамшууллыг жилийн төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хурал, эсвэл иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлснээс хойш 1 сарын дотор тогтоож, олгоно.

**дугаар зүйл. Нэмэлт төсөв**

1.171. Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно:

төсөвт хамаарахгүй этгээдээс авсан хандив, тусламж;

төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагуудаас авах хөнгөлттэй зээл;

Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө;

дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө;

төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого;

төсвийн урамшуулал.

1.172. Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

1.173. Энэ хуулийн 1.171-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## Өмч, хөрөнгө, Засгийн газрын өрийн удирдлага

**дугаар зүйл. Өмч, хөрөнгө**

1.174. Төрийн өмч, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, зарцуулалт, бүртгэл, тайлагналтын асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

1.175. Орон нутгийн өмч, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, зарцуулалт, бүртгэл, тайлагналтын асуудлыг тухайн шатны төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны  байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

1.176. Төрийн болон орон нутгийн өмчийг хувьчилсан, худалдсан, түрээсэлсэний орлого нь тухайн шатны төсвийн орлого байна.

1.177. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өөрөө санхүүжүүлснээс бусад хэлбэрээр төрийн болон орон нутгийн өмч бий болгох, худалдан авах, хуулийн этгээд үүсгэн байгуулах зардал, хувь оролцоо, дүрмийн санд оруулсан хөрөнгө, түүнтэй холбогдсон бүх төрлийн санхүүгийн хэрэгслүүд нь тухайн шатны төсвийн зарлага байна.

1.178. Газар, байгалийн баялаг, нөөцийг худалдсан, түрээсэлсэн, бусдад ашиглуулсан, барьцаалсан, урьдчилж зарсаны улмаас бий болох орлого нь төсвийн орлого байна.

**дүгээр зүйл. Засгийн газар зээл авах**

1.179. Засгийн газар дараах зорилгоор зээл авч болно:
Засгийн газрын төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;
улсын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх;
төсвийн алдагдлыг санхүүжүүлэх;
өрийг дахин санхүүжүүлэх;
улсын төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх.

**дугаар зүйл. Засгийн газар зээл олгох**

1.180. Тухайн жилийн төсвийн хуулиар эх үүсвэр нь батлагдсан тохиолдолд улсын төсвөөс дараах зорилгоор зээл олгож болно:
орон нутгийн төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх;
Засгийн газрын тусгай сангаас хуульд заасан зориулалтаар;
гадаад орон, Олон улсын байгууллагаас авсан зээлийг зориулалтын дагуу дамжуулан зээлдүүлэх.

**дугаар зүйл. Засгийн газрын баталгаа**

1.181. Засгийн газрын баталгаа нь дараах төрөлтэй байна:
зээлийн баталгаа;
төлбөрийн баталгаа;

1.182. Эх үүсвэр нь тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан тохиолдолд энэ хуулийн 1.181-д заасан баталгааг олгоно.

1.183. Засгийн газрын баталгаа нь төсвийн бүрэлдэхүүн байна.

1.184. Тухайн жилийн төсөвт батлагдсан хүрээнд Засгийн газраас олгох зээлийн баталгааг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн батална.

**дугаар зүйл. Болзошгүй өр төлбөр**

1.185. Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн талаарх мэдээллийг Улсын Их Хурал болон олон нийтэд мэдээлнэ.

1.186. Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн талаарх мэдээллийг жилийн болон тодотгосон төсвийн төлөвлөгөө, төсвийн хагас жилийн болон бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланд бүрэн тусгана.

1.187. Болзошгүй өр төлбөр, зээлийн баталгаа, тэдгээрийн мэдээлэлд Үндэсний аудитын газар хяналт тавьж, дүгнэлт гаргана.

1.188. Болзошгүй өр төлбөр, зээлийн баталгаа, тэдгээрийн учирч болзошгүй эрсдэл ба төлбөрийн хэмжээг тооцон мэдээлснийг тэдгээрийг хүлээн зөвшөөрч, өглөг үүсгэсэнд тооцохгүй.

**дугаар зүйл. Засгийн газрын өрийн удирдлага**

1.189. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын өрийн удирдлагыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

Засгийн газрын санхүүгийн хэрэгцээ, эрсдлийн үнэлгээг үндэслэж өрийн удирдлагын стратеги боловсруулж, хэрэгжүүлэх;

Засгийн газрын өрийн удирдлагын зорилт, өрийн хэмжээ, бүтэц, эрсдлийг богино, дунд хугацаагаар тодорхойлж, удирдан зохицуулах;

тухайн жилийн төсвийн хуулиар Засгийн газрын шинээр авах зээл, гаргах баталгааны дээд хязгаарыг батлуулж мөрдөх;

төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн авах зээлийн дээд хязгаарыг тогтоох;

Засгийн газрын өр болон зээлийн баталгааны мэдээллийн санг бүрдүүлэх;

аймаг, нийслэлийн Засаг даргын улсын төсвөөс авах зээлийн хэмжээний дээд хязгаарыг тогтоох;

Засгийн газрын өрийн мэдээллийн ил тод байдлыг хангах;

зээлдүүлэгчийн эрх тэгш байдлыг хангах.

1.190. Орон нутгийн төсөв нь зөвхөн улсын төсвөөс тухайн жилийн төсвийн богино хугацааны мөнгөн хөрөнгийн хэрэгцээг санхүүжүүлэх зорилгоор зээл авч болох бөгөөд зээлийн баталгаа гаргахыг хориглоно.

1.191. Хөрөнгө, өр төлбөрийн удирдлага, Засгийн газрын зээл авах, зээл олгох, дамжуулан зээлдүүлэх, зээлийн баталгаа гаргах, тэдгээрт тавигдах шаардлага, нөхцөл, хязгаарлалт, болзошгүй өр төлбөрийн удирдлагын харилцааг хуулиар зохицуулна.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## Төсвийн тайлагналт

**дүгээр зүйл. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан**

1.192. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд улс, орон нутгийн төсвийн санхүүгийн тайлан, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлан хамаарна.

1.193. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайландаа хамруулна.

1.194. Төсвийн ерөнхийлөн захирагч ньтөсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу гаргана.

1.195. Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:
үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;
санхүүгийн тайлан ;
мөнгөн гүйлгээний тайлан;
өмчийн өөрчлөлтийн тайлан;
санхүүгийн тайлангийн тодруулга.

1.196. Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна.
тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчдаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/;
татварын зарлагыг салбар, хуулийн этгээд бүрээр холбогдох хууль, эрх зүйн үндэслэлийн хамт;
тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;
хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/.
нэмэлт төсвийн гүйцэтгэл, холбогдох танилцуулга;

1.197. Энэ хуулийн 1.146 дүгээр зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана.

**дугаар зүйл. Сонгуулийн өмнөх эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайлан**

1.198. Засгийн газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуулийг зарлахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын талаархи мэдээллийг төрийн аудитын төв байгууллагад ирүүлнэ.

1.199. Энэ хуулийн 55.1-д заасан мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд төрийн аудитын төв байгууллагын дарга танилцуулна.

1.200. Улсын Их Хурал мэдээлэлтэй танилцсаны дараа төрийн аудитын төв байгууллага сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг бэлтгэж, олон нийтэд мэдээлнэ.

1.201. Сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайлан дараах мэдээллийг багтаасан байна:
сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлсэн эдийн засаг, санхүү, төсвийн бодлого, үр дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал;
ирэх 4 жилийн макро эдийн засаг, төсвийн төлөв байдлын төсөөлөл;
Засгийн газрын өр, болзошгүй өр төлбөрийн дүн, түүний зориулалт, нөхцөл, хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үндсэн өр ба хүүгийн төлбөрийн дүн;

Монгол Улсын төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдлийн нийт дүн, энэ нь төсвийн тогтвортой байдлыг хангаж байгаа эсэх болон дараагийн хоёр жилийн хугацаан дахь тухайн сангийн эх үүсвэрийн өөрчлөлтийн тухай үнэлгээ;

болзошгүй өр төлбөр;

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан, хүлээгдэж байгаа арга хэмжээ, түүнд төсвөөс гаргах зардлын хэмжээ, эх үүсвэр;

Засгийн газрын гэрээ, хэлэлцээрт тусгагдсан, хүлээгдэж байгаа Засгийн газрын өр төлбөр, баталгааны дүн;

сонгуулийн жилд Засгийн газраас гаргасан шийдвэр нь дараагийн жилүүдийн санхүү, төсвийн төлөв байдалд хэрхэн нөлөөлөх үзүүлэлт;

эдийн засаг, санхүү, төсвийн дунд хугацааны төсөөлөл нь Улсын Их Хурлаар батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, эсхүл тухайн жилийн төсөв, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа талаарх тайлбар.

1.202. Энэ хуулийн 1.201-1.201-д заасан зүйлсийн төсөвт үзүүлэх нөлөөллийг тоон илэрхийллээр харуулна.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
## Орон нутгийн төсвийн харилцаа

### дугаар зүйл. Төсвийн шатлал хоорондын харилцаа

1.203. Дээд шатны төсвөөс доод шатны төсөвт дараах хэлбэрээр шилжүүлэг олгоно:

доод шатны төсвийн үндсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд зориулан дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг;

доод шатны төсвийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхэд нь зориулж дээд шатны төсвөөс олгох орлогын шилжүүлэг;

нийслэл, хотын хөгжлийн хэрэгцээнд зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын татаас.

1.204. Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашигаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.

1.205. Дээд шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллага нь доод шатны төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, тусгай зориулалтын татаасыг дараах зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах хүртэлх хугацаанд түр зогсоох эрхтэй:

төсвийн хууль тогтоомж зөрчсөн;

орлогоо бодит бус байдлаар хэт өндөр төлөвлөсөн бөгөөд түүгээр зарлага санхүүжилт хийхээр төлөвлөсөн;

тусгай зориулалтын татаасын зориулалт, зарцуулалтын нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандартыг мөрдөөгүйгээс нийт төсөв нь алдагдалтай гарсан;

орон нутгийн төсвийн тогтвортой байдал алдагдсан;

орон нутгийн төсвийг энэ хуулиар тогтоосон хугацаанд батлаагүй;

олон нийтийн оролцоог хангаж ажиллаагүй.

1.206. Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно.

1.207. Энэ хуулийн 1.203-д заасан тусгай зориулалтын татаасын зориулалт, зарцуулалтад тавигдах нөхцөл, шаардлагыг Улсын Их Хурлаас тусгайлан тогтоож, Засгийн газар хяналт тавьж ажиллана.

1.208. Энэ хуулийн 1.205-д заасан зөрчлийг арилгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн төсвийн тогтвортой байдлыг хангуулах, төсвийн харилцаанд оролцогчдын чадавхийг дээшлүүлэх, орон нутагт энэ хуулийн 1.144-д заасан нөхцөл байдал үүсвэл төсвийн санхүүжилтийн түр горим тогтоох зорилгоор Засгийн газар болон дээд шатны төсвийн асуудал эрхэлсэн байгууллагаас тухайн орон нутагт тогтворжуулалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

**дугаар зүйл. Орон нутгийн төсөв**

1.209. Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэг, орон нутгийн төсөвт хуваарилах орлогын нэр төрлийг энэ хуулиар тогтооно.

1.210. Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ.

1.211. Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган батлаж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

1.212. Сум, дүүргийн төсвийн орлогын улирлын чанартай орлогын дутагдлын санхүүжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн төсвөөс богино хугацаатай зээл олгож болно.

1.213. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 1.212, 1.180-т зааснаас бусад тохиолдолд зээл авах, тухайн шатны төсвөөс зээл олгох, баталгаа гаргахыг хориглоно.

**дүгээр зүйл. Орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэх чиг үүрэг**

1.214. Аймаг, нийслэлийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

аймаг, нийслэлийн удирдлага;
орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн их засвар хийх;
нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ;
хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх;
Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
малжуулах, бэлчээрийн менежментийг сайжруулах;
усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламжийн болон орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, хот төлөвлөлт, үерийн хамгаалалт;
нийтийн тээврийн үйлчилгээ;
мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавьжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах;
байгаль хамгаалах;
зам, талбайн засвар үйлчилгээ;
малын тэжээлийн нөөц бүрдүүлэх;
бэлчээрийн менежмент хийх;
хуульд заасан бусад чиг үүрэг.

1.215. Сум, дүүргийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

сум, дүүргийн удирдлага;

сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгогддог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ;

нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, тохижилт, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалт, цэцэрлэгжүүлэлт, тэдгээрийн арчилгаа;

сум, дүүргийн байгаль хамгаалах;

сум, дүүргийн чанартай зам, талбайн засвар үйлчилгээ;

малын тэжээлийн нөөц бүрдүүлэх;

бэлчээрийн менежмент хийх, худаг, ус гаргах, арчлах;

сум, дүүргийн хэмжээний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр арга хэмжээ хэрэгжүүлэх;

малжуулах, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх;

сум, дүүргийн тохижилт, гудамж талбайн гэрэлтүүлэг, мод ургамал тарих, цэцэрлэгжүүлэлт, явган зам, амралт болон хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах;

сум, дүүргийн доторх өндөр хүчдэлийн болон цахилгааны шугам, дэд өртөөний хөрөнгө оруулалт;

сум, дүүргийн доторх авто зам, гүүр, түүний гэрэлтүүлэг, гэрлэн дохио болон бусад холбогдох барилга, байгууламжийн хөрөнгө оруулалт;

хуульд заасан бусад чиг үүрэг.

1.216. Аймаг, нийслэлд улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжийг Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулна.

**дугаар зүйл. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан**

1.217. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 30 хувь;

орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив.

энэ хуулийн 1.204-д заасан хөрөнгө;

1.218. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгосон шилжүүлгийн 60 хувиас доошгүйг аймаг, нийслэл нь сум, дүүргийн хөгжлийн санд энэ хуулийн 1.219-д заасан үзүүлэлтийг харгалзан хуваарилна.

1.219. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах зүйлийг үндэслэнэ:

орон нутгийн хөгжлийн индекс;

хүн амын тоо;

хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээ;

орон нутгийн татварын идэвхи санаачлага.

1.220. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлалыг Засгийн газар тогтооно.

**дугаар зүйл. Орон нутгийн хөгжлийн сан**

1.221. Орон нутаг тухайн нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна.

1.222. Орон нутгийн хөгжлийн сан нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
энэ хуулийн 1.203-д заасан хөрөнгө
энэ хуулийн 1.218-д заасан хөрөнгө;
орон нутгийн төсвийн суурь тэнцлийн ашиг;
татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж.

1.223. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:
орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ;
нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага,  улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;
үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны болон ёслолын зардал;
нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, тэдний олонхийн саналаар дэмжигдээгүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгагдаж батлагдаагүй зардал, арга хэмжээ.

**дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах**

1.224. Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангаас авч хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

1.225. Энэ хуулийн 1.224-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн хуралдээр гарсан саналыг иргэдийн Нийтийн хурал хэлэлцэн тэргүүн ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

1.226. Энэ хуулийн 1.225-т заасны дагуу баг, хороодын иргэдийн Нийтийн хурлаасирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ.

1.227. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь энэ хуулийн 1.226-т заасан саналыг хэлэлцэж, батална.

**дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

1.228. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараахь бүрэн эрхтэй:
Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;
тухайн жилийн төсөв, түүний тодотголыг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд мэдээлэх;
төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах;
төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийг сонсох.

**дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

1.229. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

тухайн шатны төсвийн төсөл, тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

орон нутаг дахь улсын төсвийн байгууллага, улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж, холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай гэрээ байгуулж ажиллах;

орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах;

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан орон нутгийн төсвийг 14 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

энэ хуулийн 1.131-д заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар, цаг хугацаанд нь, тасралтгүй бүрэн санхүүжүүлэх;

тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн эрх захирагч бүрээр батлах.

**дугаар зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

1.230. Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн удирдлага, санхүүжилтийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

орон нутаг дахь улсын төсвийн байгууллага, улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн төсөл, гүйцэтгэл, сар, улирлын мэдээ, санхүүгийн тайланг нэгтгэн боловсруулж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар сум, дүүргийн Засаг дарга дээд шатны Засаг даргатай гэрээ байгуулж ажиллах;

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан орон нутгийн төсвийг 7 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

энэ хуулийн 1.133-д заасан гэрээний дагуу улсын төсвийн байгууллагын төлөвлөсөн зардлыг зориулалтаар, цаг хугацаанд нь, тасралтгүй бүрэн санхүүжүүлэх;

тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн эрх захирагч бүрээр батлах.

**дүгээр зүйл. Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх**

1.231. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 1.232-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

1.232. Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 1.122-1.122, 1.122-д заасанаас гадна дараахь зүйлийг тусгана:

орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

энэ хуулийн 1.69 дугаар зүйлд заасан төсвийн ангилалын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;

аймаг, нийслэлээс сум дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг болон орлогын шилжүүлэгийн санал;

дээд шатны батлагдсан төсвөөр тогтоосон төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ;

1.233. Аймаг, нийслэл, сум дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

**дугаар зүйл. Орон нутгийн төсөв батлах**

1.234. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 1.124-1.124-д заасныг тусгаж, батална.

1.235. Төсвийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 1.102-д заасан шаардлагыг хангаж буй эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

1.236. Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсвийг олон нийтэд хүртээмжтэй, ил тод байдлаар мэдээлнэ.

## АРАВДУГААР БҮЛЭГ
## Хяналт, шалгалт

**дугаар зүйл. Дотоод аудит**

1.237. Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч эрсдлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитыг хэрэгжүүлнэ.

1.238. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитыг арга зүйгээр хангана.

1.239. Дотоод аудитын дүрмийг Засгийн газар батална.

**дүгээр зүйл. Санхүүгийн хяналт, шалгалт**

1.240. Засгийн газрын санхүүгийн дотоод хяналт, шалгалтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.

1.241. Санхүүгийн дотоод хяналт, шалгалтад төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит болон тэдгээрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамрагдана.

1.242. Санхүүгийн дотоод хяналт, шалгалтыг дор дурдсан чиглэлээр хийнэ:

санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт;

тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт хөрөнгийн зарцуулалт;

хөтөлбөрийн төлөвлөлт,түүний үр дүн;

өмч, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт;

санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал;

төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт;

анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан;

Засгийн газрын гадаад, дотоод зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт;

улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт;

байгууллагын нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт.

## АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## Хариуцлага хүлээлгэх

**дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

1.243. Төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч эсхүл санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч дараахь шийтгэл ногдуулна:

энэ хуулийн 1.22-д заасан холбогдох тооцоо, санал, төсөв, төсвийн төслийг тогтоосон хугацаанд нь хүргүүлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

энэ хуулийн 1.37, 1.37, 1.48-д заасан бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

энэ хуулийн 1.142, 1.117-д заасан төсвийн хэрэгжилтийн талаарх үүргээ биелүүлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

энэ хуулийн 1.229, 1.230-д заасны дагуу санхүүжилт хийгээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

энэ хуулийн 1.197 дүгээр зүйлд заасан сонгуулийн өмнөх макро эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайланг хугацаанд нь гаргаж, мэдээлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

энэ хуульд заасан олон нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

Энэ хуулийн 1.91, 1.7, 1.8, 1.134-д заасныг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнийг томилсон холбогдох эрх бүхий этгээд төрийн албанд 10 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулна.

1.244. Зөрчлийн хэлбэр, хүлээлгэх хариуцлагаас үл хамааран энэ хуулийг зөрчсөний улмаас төрд хохирол учруулсан этгээд уг хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй.

1.245. Энэ хуулийн 1.243, 1.243-д заасан шийтгэлийг шүүгч, 1.243, 1.243 -1.243-д заасан шийтгэлийг санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч тус тус ногдуулна.

**дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

1.246. Энэ хуулийг 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.247. 2012 оны төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах, 2012 оны төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахтай холбогдсон харилцааг 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн энэ хуульд заасан журмын дагуу зохицуулна.

ГАРЫН ҮСЭГ

**БАТЛАВ.**

| | |
|---|---|
| **САНГИЙН САЙД** | **ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД** |
| **С. БАЯРЦОГТ** | **Ц. НЯМДОРЖ** |

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дэх зарим төрлийн металлын үнийн өсөлтийн улмаас төсвийн орлого ихээхэн нэмэгдсэн. Төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр богино хугацаанд хүрэлцээтэй байсан боловч нийгмийн шинжтэй зарлага хэт хурдацтай нэмэгдэж, энэ нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, инфляцын хүлээлт, импортын өсөлтийг бий болгох, дотоодын үйлдвэрлэл буурахад нөлөөлж, улмаар эдийн засгийн хэт халалт бий болох зэрэг сөрөг үр дагавар үүсэх хандлагатай байна.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын төсвийн хүрээг шинэчлэн тогтоох шаардлага гарч байна. Тухайлбал, экспортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн таамаглал, шинээр ашиглаж эхлэх ашигт малтмалын орд газрууд, үйлдвэрлэлийн салбарын хөгжлийн хандлагад тулгуурлан төсвийн орлогын боломжийг тодорхойлох, улмаар нийт эдийн засагт үзүүлэх төсвийн зарлагын нөлөөлөл, мөнгө болон сангийн бодлогын уялдааг хангах замаар төсвийн алдагдлын зорилтот түвшин, зарлагын хэмжээг шинэ зарчмаар тооцоолох шаардлага гарч байна. Түүнчлэн дэлхийн санхүүгийн зах зээл дээрх хямрал, төсвийн орлогын бууралт нь төсвийн тогтолцооны үр ашигтай байдлыг дээшлүүлэх чиглэлээр өөрчлөлт, шинэчлэл хийх шаардлагыг зүй ёсоор бий болгож байна.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд тодорхойлсон гол элементүүд болох төсөвлөлт бодлогын уялдаа, төсвийн санхүүжилтийн үр дүнгийн хариуцлага, дунд хугацааны төлөвлөлтийн зарчим, төсвийн процессын журам зэрэг нь төсвийн тогтолцоо, бодлого, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэл тэдгээрийн харилцаанд шинэлэг, үр ашигтай байдлыг нэвтрүүлснээрээ чухал ач холбогдолтой болсон байна. Харин байгууллагын түвшинд төсвийн зохицуулалт, эрх мэдлийн хуваарилалтыг хэт нарийвчлан заасан, бүтээгдэхүүн гэрээлэлт, үр дүнгийн гүйцэтгэлийн удирдлагыг

сайтар тооцолгүй нэвтрүүлсэн зэрэг нь уг хуулийн харилцаанд оролцогч талуудын санал шүүмжлэлд байнга өртөх болоод байна.

Нэгдсэн төсвийн тухай хууль нь төсвийн бүрэлдэхүүн, ангилал, санхүүжилтийн хүрээ зэрэг улс орны төсөвт байвал зохих бүрдлийг агуулсан анхны төсвийн тогтолцооны хууль боловч иж бүрэн байдал талаасаа учир дутагдалтай төдийгүй бусад улс орон олон улсад хэрэглэж байгаа аргачлал, стандартад нийцээгүй, хэрэглэж байгаа нэр томъёо зөрүүтэй болсон байна.

Дээрх бие даасан хоёр гол хуулийг нэгтгэсэн байдлаар шинэчлэн найруулга хийх нь *нэгдүгээрт,* төсвийн тогтолцооны шинэчлэл хийх суурь асуудлуудад иж бүрэн, нэгдмэл, системтэй байдлаар хандаж, хэрэгжүүлэхэд дөхөмтэй болгох; *хоёрдугаарт,* төсвийн нэгдмэл байдлыг хангах замаар хариуцлагатай, үр ашигтай төсөвлөлт, гүйцэтгэл, тайлагналт болон хяналтын системийг бий болгох ач холбогдолтой юм.

Төсөв, санхүүгийн харилцааг Нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар тус тус зохицуулж байгаа боловч дараахь хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагыг харгалзсаны үндсэн дээр уг харилцааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзсэн.

*Хууль зүйн шаардлага:*

- Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2009 оны 5 дугаар сарын 14-ны өдрийн 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль, тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 151-т “Төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг, төсвийн хяналт, хариуцлагатай холбогдсон харилцаа, орон нутгийн эрх мэдэлтэй холбогдсон асуудлыг боловсронгуй болгох” талаар тусгасан. Энэ хүрээнд Нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн үндсэн үзэл санааг өөрчлөхгүйгээр төсвийн харилцааг нэгдсэн нэг хуулийн хүрээнд зохицуулах, хуулиудын давхардсан болон зөрчилтэй заалтуудыг уялдуулан нэгтгэж, засан сайжруулах;
- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх болон гүйцэтгэлд нь хяналт тавихтай холбоотой харилцаа хуулинд тусгагдаагүйгээс хөрөнгө оруулалтын үр ашиг, гүйцэтгэлийн хугацаа, чанарт доголдол гарч байгааг анхааран уг харилцааг журмаар зохицуулах талаар хуульчлах;
- Төсөв, санхүүгийн нэгдсэн удирдлагыг хангахад чиглэгдсэн мөнгөн хөрөнгийн нэгдсэн удирдлага, Засгийн газрын санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн удирдлага, нягтлан бодох бүртгэл, дотоод аудитын харилцааг хуульчлах;
- Төсвийн ил тод байдлыг хангах асуудал хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад тодорхой тусгагдаагүй тул эдгээр харилцааг зохицуулах, тухайлбал, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, болзошгүй өр төлбөр, зээл, зээлийн баталгаатай холбоотой төлөвлөлт, тайлагналтад тавигдах шаардлагуудыг нарийвчлан тодруулах;
- Дээр дурдсан асуудлуудад дүгнэлт хийж улмаар төсвийн удирдлагын зарчим, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, ангилалыг төсвийн явцын үе шатууд, төсвийн харилцаанд оролцогч субъектүүдийн эрх үүрэг, хариуцлагатай нь уялдуулсан логик дараалал бүхий системтэй бие даасан төсвийн тогтолцооны эрх зүйн орчин бий болгох зэрэг хууль зүйн шаардлага гарч байна.

*Практик шаардлага:*

1. Төсвийн хариуцлага, сахилга бат, тогтвортой байдал алдагдаж байна**.** Жилийн төсвийн төсөл хэлэлцэх, батлах үйл явцад хууль тогтоох болон гүйцэтгэх

засаглалын эрх үүрэг хуулинд тодорхойгүй байгаа нь макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх хандлага гарч байгааг засан сайжруулах;

2. Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах үзүүлэлтүүд болон түүнийг бэлтгэхэд шаардагдах тооцоо, мэдээллийн агуулгыг хуульчлах;

3. Засгийн газраас баталсан зардлын хязгаар мөрдөгддөггүй байдлыг төсвийн дунд хугацааны төлөвлөлтийг сайжруулж хэрэгжилтийг хангахуйцаар зардлын хязгаар баталж, төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлж мөрдүүлэх;

4. Төсвийн ерөнхийлөн захирагчдад зохистой хэмжээнд төсөв, санхүүгийн эрх мэдлийг шилжүүлэх, үүнтэй уялдуулж төсөв хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтны эрх үүргийг тодорхой болгож, хариуцлагыг өндөржүүлэх;

5. Төсвийн ангилал, бүрэлдэхүүнийг тодорхойлсон хуулийн нэр томъёо өөр хоорондоо зөрчилтэй, ойлгомжгүй байдлаар тусгагдсаныг нэг мөр болгох;

6. Төсөв түүний бүрэлдэхүүнд орлогыг бүрэн хамруулж чадаагүйн зэрэгцээ хуулиар тогтоогоогүй зардлууд гарч байгааг өөрчилж бүх орлого зарлагыг төсөвт хамруулдаг байх, тухайлбал, өөрийн орлого, төсвийн гадуурх сангууд, болзошгүй эрсдэл, баталгаа, амлалт зэргийг төсөвт тооцдог төсвийн иж бүрэн байдлыг хангах;

7. Бодлогын тэргүүлэх чиглэл, санхүүгийн хэрэгцээг хооронд нь уялдуулсан төсвийн төлөвлөлтийн зохистой механизм дутагдаж байна. Тухайлбал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын хөтөлбөрүүдийг төсөвтэй уялдуулсан төлөвлөлт сул байна. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчид өөрсдийн бодлогын зорилгоо хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай төсвийн эрх мэдэл, уян хатан ажиллах боломж хомс зэрэг нь төсвийн зарлагын үр ашиггүй байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдын эрх үүргийг өргөтгөж салбарын бодлого төлөвлөлттэй уялдсан, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг нэвтрүүлэх;

8. Нэгдсэн төсвийн тухай хуульд төсвийг эдийн засгийн ангилалаар харин Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд хөтөлбөрийн шинжтэй (бүтээгдэхүүн) ангилалаар хуваарилах агуулгатай заалт байгааг өөрчлөн нэг хуулийн хүрээнд нэгтгэж, эдгээр ангиллыг хослуулсан төсвийн оновчтой бүтцийг бий болгох;

9. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд төсвийн үйл ажиллагаанаас илүүтэй төсөвт нэгж, байгууллагын удирдлага зохицуулалтыг хэт нарийвчилсан зохицуулсанаар хэрэгжилтийн явцад шинэчлэлийн хүчин зүйлсийг сайжруулахад уян хатан хандах боломжийг багасгаж байгааг анхаарах;

10. Орон нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг төвлөрсөн байдлаар зохицуулж санхүүжилтийг хэт багасгасан нь орон нутгийн бие даасан байдал, бүс нутгийн хөгжил, орон нутгийн удирдлагын хариуцлагыг сулруулж, төрийн үйлчилгээ болон төсөвт тавих иргэдийн хяналтыг бууруулж байгаа байдлыг анхаарч сайжруулах;

11. Орон нутаг болон төвлөрсөн төсвийн одоогийн харилцаа нь эдийн засгийн шилжилтийн эхэн үед төсвийн зохицуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах зайлшгүй шаардлага, ойрын жилүүдэд ч энэ зарчмыг хадгалах нь үр дүнтэй байж болох ч улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох шилжүүлэг болон орон нутгийн төсөвт орох татварын уян хатан оновчтой зохицуулалт хийх;

12. Чадавхи болон хэрэгцээнд үл тохирсон, өнөөгийн нөхцөлд хэрэгжих магадлал багатай аккруэл сууриар төсөвлөх, байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, улсын салбарын удирдлагын үр дүнгийн гэрээний үнэлгээг төсөвтэй холбосон зэрэг нь бодит байдал дээр нэр төдий байдалтай байна. Тухайлбал, яам, агентлаг, төсвийн байгууллагын үйл

ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь төсөвтэй бодитой уялддаггүй, төсвийн хөрөнгө нь үр дүнд чиглэсэн арга хэмжээг санхүүжүүлэхээс илүүтэй тухайн салбар, байгууллагын зардлыг санхүүжүүлэхэд чиглэгддэг зэргийг анхаарч өөрчлөх нь зүйтэй байна.

**Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ, ерөнхий бүтэц**

*Хуулийн төслийн зохицуулах харилцаа*

Энэ хуулийн төслөөр төсөв, түүний тогтолцооны зарчим, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааны эрх зүйн үндсийг тогтооно.

*Хуулийн төслийн бүтэц:*

Хуулийн төсөл нь 11 бүлэгтэй байна.

*Нэгдүгээр бүлэгт:* хуулийн зорилт, төсвийн тухай хууль тогтоомж, энэхүү хуулийн зохицуулалтад төсвийн байгууллага, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарахаар хуулийн үйлчлэх хүрээг тогтоон, төсвийн ашиг, алдагдал, тэнцэл, хөтөлбөр, орц, эдийн засгийн ангилал, санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, Засгийн газрын өр, түүний удирдлага, татварын зардал, болзошгүй өр төлбөр зэргийг хуулийн нэр томъёонд тодорхойлох зэрэг нийтлэг үндэслэлийг тусгана.

*Хоёрдугаар бүлэгт:* Төсвийн зарчим, түүнийг хэрэгжүүлэх механизм, төсвийн жил, цагалбарыг тодорхойлно.

*Гуравдугаар бүлэгт:* Улсын Их Хурал, Засгийн газар, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд захирагчийн бүрэн эрхийг тодорхойлж, төсвийн байгууллага, тусгай сангийн ерөнхий зохицуулалт болон төсвийн ерөнхийлөн нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх асуудлыг тусгана.

*Дөрөвдүгээр бүлэгт:*Төсвийн шатлал, ангилал, орлого, зарлага болон тусламжийн орлого, түүгээр санхүүжих зарлага, мөн санхүүгийн бүртгэл, стандартыг хуульчилна.

*Тавдугаар бүлэгт:* Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, төсвийн хөрөнгө оруулалт, түүнийг төлөвлөх болон төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх хэлбэр, хэрэгжүүлэх тохиолдол, төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл, төсвийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үе шат, төсөв батлах, түүнд тодотгол хийхтэй холбогдсон харилцааг тусгана.

*Зургадугаар бүлэгт:* Төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбогдуулан төрийн сангийн үйл ажиллагааг шинээр хуульчилж, улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийг гэрээгээр хэрэгжүүлэх, үр дүнгийн гэрээ, төсвийн хэрэгжилт, төсвийн захирагчийн төсөв зохицуулалт хийх, төсвийн жил дамжин хэрэгжих арга хэмжээний зохицуулалт, туслах үйл ажиллагаа, төсвийн зарлагын хэмнэлт, урамшуулал, нэмэлт төсвийн асуудлыг тусгана.

*Долдугаар бүлэгт:* Хөрөнгийн болон өрийн удирдлага, Засгийн газрын зээл авах, олгох харилцаа, Засгийн газрын баталгаа, болзошгүй өр төлбөрийн асуудлыг шинээр хуульчлах,

*Наймдугаар бүлэгт:* Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сонгуулийн өмнөх эдийн засаг, санхүү, төсвийн төлөв байдлын тайлан, санхүүгийн мэдээллийн нэгдсэн сүлжээний талаар болон төсвийн шатлал хоорондын харилцааг хуульчилна.

*Есдүгээр бүлэгт:* Орон нутгийн төсвийн харилцааны асуудлыг тусгана. Тухайлбал, орон нутгийн төсөв, түүгээр хэрэгжүүлэх чиг үүрэг болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн болон орон нутгийн хөгжлийн сангийн зохицуулалтыг тусгана. Мөн орон нутгийн төсөвт иргэдийн оролцоог хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын бүрэн эрх, орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах харилцааг тусгана.

Энэ бүлэгт нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлж, түүний эдийн засаг санхүүгийн үндсийг бэхжүүлэх үүднээс төсөв санхүүгийн эрх мэдлийн зохистой хэсгийг нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх мэдэлд шилжүүлэх замаар төвлөрүүлэх болон эс төвлөрүүлэх ёсны тэнцвэртэй харьцааг хангана. Төрийн үйлчилгээг /боловсрол, эрүүл мэнд/ улсын төсвийн ерөнхийлөн захирагчдаас гэрээний үндсэн дээр авах одоогийн зарчмыг хадгална. Орон нутгийн удирдлагын санхүүгийн эрх мэдлийг өргөтгөх, уян хатан байдлыг хангах зорилгоор тухайн төрийн үйлчилгээний салбарын багцад нь багтаан орон нутаг зохицуулалт хийх эрх мэдлийг олгоно. Орон нутгийн өмчтэй холбоотой их засварын зардал болон түүний ашиглалт, хамгаалалттай холбоотой урсгал зардлыг улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлэхээр тогтооно. Орон нутгийн төсвийн үйл явцын дараалал нь улсын төсвийн үйл явцын дараалалтай ижил байх бөгөөд дунд хугацааны төсвийн хүрээнд хөтөлбөрөөр төлөвлөх, улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хүрээнд орон нутгийн хөрөнгө оруулалтыг удирдан санхүүжүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг чанд сахих зэрэг төсвийн болон эрх үүргийн хязгаарлалтыг мөрдөхөөр хуульчилна.

Төсвийн төлөвлөлтийн бодит байдлыг хангах, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах зорилгоор аймаг нийслэлийн Засаг даргын эрх үүргийг нэмэгдүүлнэ.

*Аравдугаар бүлэгт:* санхүүгийн хяналт, шалгалт, дотоод аудитын асуудлыг шинэчлэн тусгана.

*Арваннэгдүгээр бүлэгт:* төсвийн сахилга батыг чангатгах, хариуцлагын тогтолцоог сайжруулах үүднээс төсвийн байгууллага, албан тушаалтан, төсвийн захирагчийн хууль бус шийдвэр, арга хэмжээг тогтоож, хуулиар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн нь нотлогдвол хүлээлгэх хариуцлагыг ойлгомжтой, хэмжигдэхүйц, хэрэгждэг байхаар хуульчилна.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар**

Төсвийн тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол улсад төсвийн талаарх эрх зүйн орчин бусад улс орны төсвийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн нэгэн адил ойлгомжтой, системтэй болж төсөв боловсруулах, гүйцэтгэх, хяналт тавих үе шатанд холбогдох этгээдийнн үүрэг хариуцлага сайжирч төсвийн сахилга бат дээшилнэ.

Хуулийн төсөлд тусгасан дунд хугацааны хөтөлбөрийн төлөвлөлтийг хэрэгжүүлсэнээр засгийн газрын бодлого үйл ажиллагааг үр дүнтэй санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

**Дөрөв. Хуулийн төслийн бусад хууль, тогтоомжтой хэрхэн уялдах тухай**

Төсвийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль, тэдгээрийн үзэл баримтлал, агуулга, зарчимтай бүрэн нийцэж байгаа болно. Төсвийн тухай хууль нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон үндсэн зарчим, төсвийн тусгай шаардлагыг дагаж мөрдөх процессийн шинжтэй хууль байна.

Төсвийн тухай хуулийн төслийг батлахтай холбогдуулан Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Нэгдсэн төсвийн тухай хуулиудыг хүчингүй болгох шаардлагатайгаас гадна дараах хуулиудад агуулгын болон редакцийн шинж чанартай өөрчлөлт оруулах шаардлагатай. Үүнд:

1. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль
2. Архивын тухай хууль
3. Ашигт малтмалын тухай хууль
4. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль
5. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хууль
6. Бууны албан татварын тухай хууль
7. Боловсролын тухай хууль
8. Газрын төлбөрийн тухай хууль
9. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
10. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
11. Концессийн тухай хууль
12. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
13. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
14. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль
15. Нийгмийн даатгалын тухай хууль
16. Нийгмийн халамжийн тухай хууль
17. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
18. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль
19. Статистикийн тухай хууль
20. Татварын ерөнхий хууль
21. Төрийн аудитын тухай хууль
22. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль
23. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
24. Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хууль
25. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
26. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

27. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль
28. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Мөн “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлах тухай” УИХ-ын 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй болгох шаардлагатай болно.

--------------------000---------------------